БАТЛАВ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Н.БАЗАРРАГЧАА

АХМАД НАСТАНД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорнод аймаг 2025 оны 05 дугаар сарын 08 өдөр

Ерөнхий зүйл

Энэ техникийн тодорхойлолт нь Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

Ажлын цар хүрээ

Тус үйлчилгээг Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах 2024 оны А/75,514 тушаалаар батлагдсан журмын хүрээнд ахмад настнуудад үйлчилгээ үзүүлнэ.

Тавигдах шаардлага

№	Нэр, төрөл	Тавигдах шаардлага
2	Төсөвт өртөг	1-р багц төсөв 45,960,000 төгрөг 2-р багц төсөв 30,640,000 төгрөг 3-р багц төсөв 23,100,000 төгрөг
2	Багцтай эсэх	**1-р багц: Идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээ** /Ахмад настны тухай хуулийн 7.1.1,7.1.2,7.1.5,7.1.9,7.1.10,7.1.11 хэсэгт заасан үйлчилгээнүүдийг Хэрлэн сумын 1,2 дугаар түвшний **1965** ахмад настанд **2- багц: Идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээ** //Ахмад настны тухай хуулийн 7.1.1,7.1.2,7.1.5,7.1.9,7.1.10,7.1.11 хэсэгт заасан үйлчилгээнүүдийг бусад 13 сумын 1,2 дугаар түвшний **1310** ахмад настанд **3 -р багц: Өдрөөр асрах үйлчилгээ: Ахмад настны тухай хуулийн 7.1.6-д заасан үйлчилгээ** /Хэрлэн сумын 2,3 дугаар түвшний 165 ахмад настанд /
2	Тусгай зөвшөөрөл	Шаардахгүй
3	Ерөнхий шаардлага	**1-р багц:** -Эрх бүхий албан тушаалтнаар батлуулсан Үйлчилгээ үзүүлэх календарчилсан төлөвлөгөөний хуулбар - Үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан,үйл ажиллагааны менежерийг орон тоогоор, багш,сэтгэл зүйч, эмч, хуульч, сувилагч, үйлчилгээний ажилтныг гэрээгээр ажиллуулж байгааг нотлох тушаал шийдвэр, гэрээний хуулбар ,

		- Боловсон хүчин мэргэжлийн диплом, үнэмлэхний хуулбар -Ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, - Идэвхтэй насжилтыг дэмжих төв/ Ахмадын өргөө/-ний үйлчилгээний баталгаажсан хөтөлбөр, төлөвлөгөөний хуулбар -Ахмад настны тоо, хуваарь, өрөө тасалгаа,байршлаар 7 хоног, сар бүр зохион байгуулах сургалт, арга хэмжээний төлөвлөгөөний хуулбар -Сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх -Аж ахуй нэгж төрийн бус байгууллагын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар -Үйлчилгээ үзүүлэх сонгон шалгаруулалтад оролцох тухай Оршин суугаа газрын хаяг, харилцах утас, цахим шуудан, Үйлчилгээний чанарт тавигдах шалгуур /журам/ аргачлал, заавар,үнэ тарифыг хүлээн зөвшөөрсөн гэх мэт холбогдох бусад мэдээллийг тусгасан албан хүсэлт. -Иргэдийн нууцыг хадгалах, Архи,мансууруулах донтой,сэтгэцийн сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх талаар тусгасан дотоод журмын хуулбар -Өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байхыг нотолсон баримт 6-сараас дээш хугацаагаар байгуулсан түрээсийн гэрээ , -Аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин хүртээмжтэй дэд бүтэц, интернэт, харилцаа холбоо, байгууллагын нэр, холбоо барих утас,байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх, идэвхтэй насжилтыг үзүүлэх анги, танхим, техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх, яаралтай үед хэрэглэх эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байхыг нотолсон мэдээлэл, зураг, тодорхойлолтыг хавсаргах **2-р багц** 1-р багцийн шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлага тавигдана -Орон нутагт ажиллахад шаардагдах өөрийн унаа эсхүл гэрээт автомашинтай байхыг нотолсон гэрээ эсхүл гэрчилгээг ирүүлэх **3-р багц:** 1-р багцийн шаардлагаас гадна дараах нэмэлт шаардлага тавигдана. -Үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан,эмч,сувилагч, асрагч, тогооч, туслах тогооч, үйлчилгээний ажилтныг орон тоогоор, сэргээн засалтын эмч,сэтгэцийн эмч, сэтгэл зүйчийг гэрээгээр ажиллуулж байгааг нотлох тушаал шийдвэр, гэрээний хуулбар ,

		- Боловсон хүчин мэргэжлийн диплом, үнэмлэхний хуулбар, - Ажилтын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, -Сургалт, кейс менежментийн үйлчилгээний хөтөлбөр, ажиллах төлөвлөгөө - Эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин, хүртээмжтэй дэд бүтэцтэй ,хөдөлгөөн хийх эмчилгээ зөвлөгөөний тусдаа өрөөтэй байх,байгууллагын нэр, холбоо барих утас, байршил ажиллах цагын хуваарийг ил тод байршуулсан байх,техник тоног төхөөрөмж өөрийн эсвэл түрээсийн авто машинтай байх, интернет харилцаа холбоотой байх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэйг нотлох мэдээлэл хавсарган ирүүлэх
4	Тусгай шаардлага	Үйлчилгээ үзүүлэх байранд байнгын интернэт орчин бүрдүүлж,компьютер техник тоног төхөөрөмжөөр ханган,халамжийн нэгдсэн систем / E-halamj.mn/холбогдох боломжийг бүрдүүлсэн байна. -Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд бүртгэлтэй байх -Нэг байгууллага хэд хэдэн багцад оролцох боломжтой

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОТГОНБАВУУ